

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: САГ-2019/45/СТА-ТӨААТҮГ

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨААТҮГ	Төрийн Өмчит Аж Ахуйн Тооцоот Үйлдвэрийн газар
НДШ	Нийгмийн Даатгалын Шимтгэл
ХХК	Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани

Агуулга

Аудитын гэрчилгээ.....	2
1 Аудитын тайлан.....	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.8.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл.....	8
2.8.2 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал.....	8
2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	9
2.11. Шилэн дансны мэдээлэл.....	9
2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	
3 Менежментийн захидал.....	11
3.1 Зардалтай холбоотой асуудал	11
3.1.2 Эрсдэл:.....	11
2.1.2 Өгсөн зөвлөмж:.....	11
3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:.....	12
3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:.....	12
4 Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	12
4.4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан.....	13
4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан	14
4.3 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан	15
4.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан	16
5 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	21



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2019.03.20 № 06/519
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Эрчим хүчний хөгжлийн төв" ТӨААТҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол "Эрчим хүчний хөгжлийн төв" ТӨААТҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар "Эрчим хүчний хөгжлийн төв" ТӨААТҮГ-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал


Санхүүгийн тайланд тайлагнасан авлагаас 188 харилцагчийн 766.4 сая төгрөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, үүнээс 39 харилцагчийн 595.9 сая төгрөгийн авлагыг 2012 оноос хойш одоо хүртэл барагдуулаагүй зарим харилцагч нар нь тодорхой бус байна. Шатахуун зарцуулалтын тооцоо хийхгүйгээр 54,9 сая төгрөгийг шатахууны картанд шилжүүлсэн дүнгээр зарлагадсан зэрэг нь үнэн зөв байх, иж бүрэн байх батламж мэдэгдэлүүдтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна." 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." 20 дугаар зүйлийн 20.2.6-д "Бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах", Монгол улсын Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан "Маягт заавар батлах тухай" журмын заалтуудтай нийцэхгүй байна.

Үүрэг, хариуцлага

"Эрчим хүчний хөгжлийн төв" ТӨААТҮГ-ын удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

“Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, дүгнэлтийг “Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын захирал А.Бямбадорж танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн зардал, авлага, тайлагналтай холбоотой зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайланг батлагдсан ангилал үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

“Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт гаргах нь энэхүү аудитын зорилт байв.

“Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 10 дугаар сарын 03-наас 2019 оны 03 дугаар сарын 09-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 03 дугаар сарын 15-ний өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн “Шонхор үнэлгээ Аудит” ХХК-ийн аудитын баг хариуцаж хэрэгжүүлэв.

“Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайланг Шонхор үнэлгээ Аудит ХХК-д 2019 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 1/147 дугаар албан бичгээр ирүүлсэн.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, СТОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

“Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Эрчим хүчний салбарт улсын төсвийн болон гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, зээл тусламжаар хэрэгжих төсөл хөтөлбөр, арга хэмжээнд захиалагчийн хяналт тавих, эрчим хүчний барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх, дүгнэлт гаргах, эрчим хүчний хуулийн дагуу тусгай зөвшөөрөл олгох, мэдээллийн сан бүрдүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэх эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2016 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 308 дугаар тогтоолд “Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эрчим хүчний салбарт улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламж, концесс, гадаад хамтын ажиллагаа болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээнд гэрээгээр ажил гүйцэтгэх, захиалагчийн хяналт тавих;
- Эрчим хүчний барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийж дүгнэлт гаргахтай холбогдох бусад ажлуудыг зохион байгуулах;
- Эрчим хүчний салбарын ажилтныг мэргэжил эзэмшүүлэх, давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэшсэн зөвлөх инженерийн зэрэг олгох, төсөвчний анхан шатны болон зэрэг олгох сургалтын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;

- Цахилгаан болон дулаанжуулалтын зуух, турбин тоноглолын найдвартай байдлыг хангах зорилгоор эрчим хүчний салбарын сорил шинжилгээний лаборатори ажиллуулах;
- Эрчим хүчний барилга байгууламж , зураг төсөл ТЭЗҮ боловсруулах тусгай зөвшөөрөл эсэх асуудлаар урьдчилсан дүгнэлт гаргах;
- Иргэн хуулийн этгээдийн эрчим хүчний бодит хэрэглээ, эрчим хүчний зардал, барилга байгууламжийн хийцэд тооцоо судалгаа, дүн шинжилгээ хийх, хэмнэх боломжийн талаар ерөнхий дүгнэлт боловсруулах, зөвлөмж гаргах;
- Эрчим хүчний чиглэлээр олон улсын болон дотоодын хурал уулзалт зохион байгуулах, оролцох, туршлага судлах;

“Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

“Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын удирдлага Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

Төсвийн тухай хууль

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль

- Шилэн дансны тухай хууль
- Эрчим хүчний тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Эрчим хүчний хэмнэлтийн тухай хууль
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль
- Хүн амын орлогын албан татварын тухай хууль
- Компанийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй болно.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

“Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

“Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитын томилогдсон баг гүйцэтгэлээ.

“Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Даймонд” програм хангамж ашигладаг байна.

“Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад “Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 4 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 2 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн 2 хувиар сонгов. Харьцангуй тогтвортой суурь гэж үзэн нийт хөрөнгийг сонгосон болно.

“Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлангаар нийт хөрөнгө 24,432.6 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 488.7 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2 хувиар тооцсон нь төлөвлөлтийн шатанд эрсдэлийн түвшинг дунд зэргийн гэж үнэлсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 7 чиглэлээр аудитын 10 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 4 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 4 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 2 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

2.8.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах асуудлыг залруулан санхүүгийн тайланд тусгаж, “Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын удирдлагаар зөвшөөрүүлэн баталгаажуулав. Үүнд:

1. Шүүхийн шийдвэрээр бусдад төлсөн 52.8 сая төгрөгийг зардалд оруулсан нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 12.8.-д “Дор дурдсан зардал албан татвар ногдох орлогоос үл хасагдана”; 12.8.2-д “албан татвар төлөгчийн буруутай үйл ажиллагаатай холбогдон төлсөн торгууль, алданги, бусдад учруулсан хохирлыг нөхөн төлсөн төлбөр” гэсэн заалттай нийцэхгүй байна гэж үзээд зардлыг бууруулан залруулга хийлгэсэн.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

2.8.2 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(сая төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	2	54.9	
2	Албан шаардлага өгсөн	1	767.2	
	Дүн	3	822.1	

2.8.2.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

Асуудал 1: Зардлын талаар

1. Амралтын болон ажилласан хоног давхардуулан 2 ажилтанд 0,8 сая төгрөгийн цалин илүү олгосон.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 18.1.3-д “ажил, амралтын цагийн горим тогтоох”; 49.6-д “Цагаар ажилласан ажилтны цалин хөлсийг гүйцэтгэсэн ажлын хэмжээ, ажилласан цагаар нь тооцож тухай бүр олгоно” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдэл:

Байгууллагыг хохиролгүй болгох албан шаардлага хүргүүлж байна.

Асуудал 2: Авлагын талаар

1. Санхүүгийн тайланд тайлагнасан авлагаас 188 харилцагчийн 766.4 сая төгрөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, үүнээс 39 харилцагчийн 595.9 сая төгрөгийн авлагыг 2012 оноос хойш одоо хүртэл барагдуулаагүй зарим харилцагч нар нь тодорхой бус байна.

Шийдэл:

Авлагын тооцоо нийлж баталгаажуулах, барагдуулах талаар тодорхой ажил зохион байгуулах, төлбөр барагдуулах этгээд төлж чадахгүй болсныг нотлох хууль эрхзүйн актыг үндэслэн шийдвэр гаргах ажил зохион байгуулах албан шаардлага хүргүүлж байна.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Хан-Уул дүүргийн Татварын хэлтсийн даргын 2014 оны 2/296 дугаар албан бичгийг үндэслэн Нэмэгдсэн өртгийн албан татвар суутган тооцох татвар төлөгчөөр бүртгүүлэх орлогын хэмжээнд хүрсэн хэдий ч өнөөдрийг хүртэл бүртгүүлээгүй байгаа нь татвар хүү торгуулийн өр үүсэх эрсдэлтэй.

Хөрөнгийн дахин үнэлгээг “Цэц-Эксперт” ХХК-ийн үнэлгээчин санхүүгийн тайлагналын бодит үнэ цэнийг 16,914.5 сая төгрөг гэж тооцоолж, компанийн газар эзэмших эрх, барилга, байгууламжийн нийт хөрөнгийг үнэлж, дүгнэлт өгсөн. Тоног төхөөрөмжийн шинж чанар, ангиллаас хамаарч барилга байгууламж руу шилжүүлэх болон шилжсэн хөрөнгийг дараагийн аудитад хамруулан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Зорилтот түвшинд үндсэн үйл ажиллагааны борлуулалтын орлого 7,821.0 сая төгрөгөөр батлагдсанаас, гүйцэтгэлээр 7,064.9 сая төгрөгийн орлого бүрдүүлэн, төлөвлөгөөг 90,3 %-иар биелүүлсэн. Нийт зардлыг 8,096.0 сая төгрөг байхаар баталснаас гүйцэтгэлээр үйл ажиллагааны зардалд 7,128.3 сая төгрөгийг зарцуулж, 967.7 сая төгрөгийг хэмнэн ажиллажээ.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу тус байгууллагын цахим хуудас болон шилэн дансны нэгдсэн shilendans.gov.mn-ээс 2018 оны мэдээллүүдийг шалгаж үзэхэд санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг мэдээлээгүй, санхүүгийн тайлангийн 1 мэдээллийг оруулаагүй, хугацаа хожимдсон 12 мэдээлэл байна.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 3 зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр,үндэслэл

Бид “Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайланд аудит хийхдээ АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тусгасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидал АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтэд үндэслэсэн болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь “Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Зардалтай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Тайлант онд 54,9 сая төгрөгийг шатахууны картанд шилжүүлэн, шатахуун зарцуулалтын тайлан гаргаагүй, холбогдох албан тушаалтнаар гарын үсэг зурж баталгаажуулдаггүй, зарцуулсан байна.

Энэ нь “үнэн зөв байх” гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна"; 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"; гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Шатахууны зардал бодитоор тайлагнагдахгүй байх.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Шатахуун зарцуулалтын тооцоог хийж зардлыг бодитоор бүртгэх.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Нөхөж тооцоо хийнэ. 2019 оноос сар бүр хийж байгаа.

3.2 Тайлагналтай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт: 2018 онд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайланг 4 улирал дараалан илгээгээгүй байна. Цахим тайлангаас тулгаж үзэхэд 2018 оны 1,2,4 улирлын тайланг хадгалсан төлөвт, 3 дугаар улирлын тайланг илгээгүй байна.

Энэ нь “иж бүрэн байх” батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 21.4-д “Албан татвар төлөгч энэ хуулийн 21.3-д зааснаар хүргүүлсэн хуваарийн дагуу сар бүрийн 25-ны дотор албан татварыг урьдчилан төлж, татвар төлөлтийн улирлын тайланг дараа улирлын эхний сарын 20-ны дотор, жилийн эцсийн тайланг дараа оны 02 дугаар сарын 10-ны дотор харьяалах татварын албанд тушааж, албан татварын жилийн эцсийн тооцоо хийнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

3.2.2 Эрсдэл:

Ажлын хариуцлагагүйгээс шалтгаалж төрийн өмчит аж ахуйн нэгж өндөр торгууль төлөх

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Тайлангаа хуулийн хугацаанд хүргүүлж байх.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудит хийгдсэний дараа тайлангаа илгээнэ.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 06 сарын 10-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Балансын зүйл	2017 оны 12 сарын 31	2018 оны 12 сарын 31
1	ХӨРӨНГӨ	0.00	0.00
1.1	Эргэлтийн хөрөнгө	0.00	0.00
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	1,210,771,807.40	557,706,198.25
1.1.2	Дансны авлага	935,487,595.59	993,605,840.95
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	1,785,360.45	248,855.00
1.1.6	Бараа материал	275,116,816.76	384,852,902.64
1.1.7	Урьдчилж төлсөн зардал тооцоо	50,810,282.70	71,190,420.34
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	2,473,971,862.90	2,007,604,217.18
1.2.1	Үндсэн хөрөнгө	10,477,545,673.69	10,741,684,392.75
1.2.2	Биет бус хөрөнгө	40,624,498.48	11,681,896,516.85
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	10,518,170,172.17	22,423,580,909.60
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	12,992,142,035.07	24,431,185,126.78
2.1.1.1	Дансны өглөг	257,628,447.74	150,147,690.56
2.1.1.3	Татварын өр	36,519,829.150	1,110,117.90
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	2,940,768,640.01	2,069,496,193.12
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	3,234,916,916.90	2,220,754,001.58
2.1.2.1	Урт хугацаат зээл	3,731,110,140.00	3,731,110,140.00
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	3,731,110,140.00	3,731,110,140.00
2.2	Өр төлбөрийн нийт дүн	6,966,027,056.90	5,951,864,141.58
2.3.1	Төрийн өмч	2,637,320,333.16	2,637,320,333.16
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	1,075,302,847.21	1,888,197,225.37
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	1,073,824,953.41	12,740,903,531.19
2.3.9	Хуримтлагдсан ашиг	1,239,666,844.39	1,212,899,895.48
2.3.11	Эздийн өмчийн дүн	6,026,114,978.17	18,479,320,985.20
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	12,992,142,035.07	24,431,185,126.78

4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан

2018 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	6,804,190,114.10	7,064,962,428.03
2	Борлуулалтын өртөг	16,899,321.46	53,272,843.74
3	Нийт ашиг (алдагдал)	6,787,290,792.64	7,011,689,584.29
4	Түрээсийн орлого	63,000,000.00	96,450,000.00
5	Хүүгийн орлого	14,704,580.07	6,498,117.54
8	Бусад орлого	296,795,303.86	134,792,843.27
9	Борлуулалт, маркетингийн зардал	0.0	0.0
10	Ерөнхий ба удирдлагын зардал	5,991,452,175.35	7,128,383,009.76
12	Бусад зардал	220,434,148.00	
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	35,288,499.28	10,736,779.57
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	278,641,669.93	120,683,135.92
17	Бусад ашиг (алдагдал)	270,775,892.51	
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	365,198,291.50	11,101,178.99
19	Орлогын татварын зардал	36,519,829.15	1,110,117.90
20	Татварын дараах ашиг (алдагдал)	328,678,462.35	9,991,061.09
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	328,678,462.35	9,991,061.09

4.3 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2016 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	2,637,320,333.16	1,075,302,847.21	993,388,457.48	870,495,724.04	5,576,507,361.89
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.0	0.0	0.0	40,492,658.00	0.0
Залруулсан үлдэгдэл	2,637,320,333.16	1,075,302,847.21	993,388,457.48	910,988,382.04	5,617,000,019.89
Өмчид гаргасан өөрчлөлт	0.0	0.0	80,436,495.93	0.0	80,436,495.93
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.0	0.0	0.0	328,678,462.35	328,678,462.35
2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	2,637,320,333.16	1,075,302,847.21	1,073,824,953.41	1,239,666,844.39	6,026,114,978.17
Залруулсан үлдэгдэл	2,637,320,333.16	1,075,302,847.21	1,073,824,953.41	1,239,666,844.39	6,026,114,978.17
Бусад дэлгэрэнгүй орлого	0.0	0.0	0.0	2,876,840.00	2,876,840.00
Өмчид гаргасан өөрчлөлт	0.0	812,894,378.16	14,277,777.78	0.0	827,172,155.94
Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0	-39,634,850.00	-39,634,850.00
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.0	0.0	0.0	9,991,061.09	9,991,061.09
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.0	0.0	11,652,800,800.0	0.0	11,652,800,800.0
2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	2,637,320,333.16	1,188,197,225.37	12,740,903,531.19	1,212,899,895.48	18,479,320,985.20

4.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.0	0.0
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	8,678,840,461.58	6,489,182,893.62
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	8,182,619,323.02	6,315,996,009.00
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	0.00	80,620,039.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	496,221,138.56	92,566,845.62
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	5,779,085,529.08	7,110,500,095.08
1.2.1	Ажиллагчдад төлсөн	2,351,206,119.92	3,002,704,991.04
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	510,350,743.55	716,530,609.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	338,962,724.00	691,942,129.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	313,980,185.07	62,681,413.23
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	57,542,685.00	55,800,000.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	33,154,062.00	
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	272,358,004.00	388,935,916.00
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	55,883,932.00	57,463,854.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	1,845,647,073.54	2,134,441,182.81
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	2,899,754,932.50	621,317,201.46
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	14,704,580.07	6,498,117.54
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	14,704,580.07	6,498,117.54
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	3,636,649,159.12	56,980,000.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	3,636,649,159.12	53,680,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	3,621,944,579.05	50,481,882.46
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	239,448,060.32	22,093,003.69
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	224,018,603.38	8,000,000.00
.	Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	15,429,456.94	14,093,003.69
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	50,717,956.22	3,359,528.92
..	Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	50,717,956.22	3,359,528.92
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	188,730,104.10	18,733,474.77
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	533,459,542.45	653,065,609.15
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,744,231,349.85	1,210,771,807.40
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,210,771,807.40	557,706,198.25

“Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

Төрийн аудитын байгууллагаас хийсэн санхүү, гүйцэтгэл, нийцлийн
аудитын хураангуй тайлангийн хавсралт

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2018.12.31	Аудитын нэр:	2018 оны санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:	САГ-2019/45/СТА-ТӨҮГ
Шалгагдсан	“Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ			сая төгрөгөөр	

№	Аудитын зорилт, чиглэл	Тоо	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл			Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
					Нэр	Огноо	Дугаар	Албан тушаал	Овог нэр
A	1	2	3	4	5			9	10
1	Цалин хөлс	1	Амралтын болон ажилласан хоног давхцсанаас 2 ажилтанд цалин илүү олгосон.	0.8	Албан шаардлага өгсөн			Захирал, Нягтлан бодогч	А.Бямбадорж, Д.Эрдэнэчимэг
2	Зардал	1	Шатахуун зарцуулалтын тооцоо хийхгүйгээр 54,9 сая төгрөгийг шатахууны картанд шилжүүлсэн дүнгээр зарлагдсан нь	54.9	Зөвлөмж өгсөн			Захирал, Нягтлан бодогч	А.Бямбадорж, Д.Эрдэнэчимэг
3	Авлага	1	Санхүүгийн тайланд тайлагнасан авлагаас 188 харилцагчийн 766.4 сая төгрөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, 39 харилцагчийн 595.9 сая төгрөгийн авлагыг 2012 оноос хойш одоо хүртэл барагдуулаагүй зарим харилцагч нар нь тодорхой бус байна.	766.4	Албан шаардлага өгсөн			Захирал, Нягтлан бодогч	А.Бямбадорж, Д.Эрдэнэчимэг
4	Тайлагнал	1	2018 онд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайланг 4 улирал дараалан илгээгээгүй байна.Цахим тайлангаас тулгаж үзэхэд 2018 оны 1,2,4 улирлын тайланг хадгалсан төлөвт,3 дугаар улирлын тайланг илгээгүй байна.		Зөвлөмж өгсөн			Захирал, Нягтлан бодогч	А.Бямбадорж, Д.Эрдэнэчимэг
нийт дүн				822.1					

